



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/30/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Д.Даариймаа Утас:88555089 Цахим хаяг: daariimaad91@gmail.com</p>
--------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Contents

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.08 № 35

танай _____ -ны № _____ Т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ӨНӨРБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

006020071

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,522,277.00</u>	<u>40,012,827.00</u>
33	АВЛАГА	2,126,704.00	11,686,554.00
335	Бусад авлага	2,126,704.00	11,686,554.00
3351	Байгууллагаас авах авлага	1,029,260.00	10,589,110.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,097,444.00	1,097,444.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,395,573.00	28,326,273.00
351	Түүхий эд материал	557,412.00	557,412.00
35110	Тусгай зориулалттай материал	557,412.00	557,412.00
354	Хангамжийн материал	12,838,161.00	27,768,861.00
35410	Бичиг хэргийн материал	22,000.00	1,057,700.00
35420	Аж ахуйн материал	11,810,161.00	25,705,161.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,000.00	6,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,102,041,694.48</u>	<u>3,278,758,167.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,102,041,694.48	3,278,758,167.43
392	Биет хөрөнгө	3,091,111,694.48	3,267,828,167.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,374,953,957.58	2,449,953,957.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(254,099,038.80)	(363,654,744.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	217,703,313.00	217,703,313.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(165,553,568.52)	(175,291,960.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	513,788,545.40	533,656,655.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(111,389,516.96)	(143,503,354.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,557,595.77	33,597,605.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,685,842.65)	(23,606,960.05)
39209	Зам, гүүрийн байгууламж	365,999,900.00	611,530,050.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(42,516,612.74)	(58,566,600.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	217,308,631.00	237,393,890.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,955,668.60)	(51,383,684.60)
393	Биет бус хөрөнгө	10,930,000.00	10,930,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,630,000.00	10,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,117,563,971.48</u>	<u>3,318,770,994.43</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,116,126,571.48</u>	<u>3,318,770,994.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,116,126,571.48	3,318,770,994.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	721,053,754.60	721,053,754.60
51101	Өмч: - төрийн	721,053,754.60	721,053,754.60
512	Хуримтлагдсан үр дүн	1,529,380,019.74	1,732,024,442.69
51210	Өмнөх үеийн үр дүн	1,529,380,019.74	1,529,788,159.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	202,236,282.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	865,692,797.14	865,692,797.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,117,563,971.48</u>	<u>3,318,770,994.43</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	511,647,480.00	916,614,808.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,529,840.00	382,449,429.00
120	Нийтлэг татварын бус орлого	86,529,840.00	357,449,429.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,529,840.00	357,449,429.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	722,000.00	552,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,807,840.00	356,897,429.00
122	Тусламжийн орлого	-	25,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	25,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	425,117,640.00	534,165,379.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,619,690.00	115,293,579.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,549,690.00	115,293,579.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	690,150.00	418,871,800.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	690,150.00	418,871,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	673,948,298.34	707,878,524.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673,948,298.34	707,878,524.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	663,333,095.00	662,946,175.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,113,476.00	245,876,217.00
210101	Үндсэн цалин	160,196,343.69	176,036,606.00
210102	Нэмэгдэл	42,373,827.00	54,881,002.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,543,305.31	14,958,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,164,174.88	30,407,406.00
210201	Тэтгэврийн даатгал	18,879,700.00	20,861,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,374.88	2,354,463.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,635,800.00	1,972,784.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,900.00	472,678.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,089,400.00	4,746,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,440,850.66	43,581,132.00
210301	Гэрэл, цахилгаан	8,886,345.00	9,064,686.00
210302	Түлш, халаалт	36,529,737.66	34,416,446.00
210303	Цэвэр, бохир ус	24,768.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,514,220.00	14,275,030.00
210401	Бичиг хэрэг	2,972,510.00	2,425,500.00
210402	Тээвэр, шатахуун	17,834,730.00	9,799,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,706,980.00	1,880,680.00
210404	Ном, хэвлэл	-	169,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,280,480.00	19,288,246.00
210604	Урсгал засвар	8,280,480.00	19,288,246.00
2107	Томилолт, зочны зардал	8,108,000.00	1,218,000.00
210702	Дотоод албан томилолт	6,608,000.00	1,218,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,685,235.00	2,568,475.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,918,076.00	1,810,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	324,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	318,284.00	287,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	352,875.00	146,575.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	336,311,473.46	305,731,669.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,985,693.14	116,220,914.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	207,345,780.32	189,510,755.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,615,203.34	44,932,349.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,986,000.00	21,694,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	21,694,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,629,203.34	23,238,149.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,629,203.34	23,238,149.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(162,300,818.34)	208,736,283.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.16	6,500,000.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.16	6,500,000.14
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(0.16)	(6,500,000.14)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(162,300,818.50)	202,236,282.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	533,152,733.14	534,717,379.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,845,850.00	552,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,845,850.00	552,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,845,850.00	552,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	722,000.00	552,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	531,306,883.14	534,165,379.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,808,933.14	115,293,579.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,738,933.14	115,293,579.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	690,150.00	418,871,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	690,150.00	418,871,800.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	468,432,743.14	527,419,379.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,432,743.14	527,419,379.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	457,817,539.80	471,897,920.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,113,476.00	245,876,217.00
210101	Үндсэн цалин	162,550,016.69	176,015,206.00
210102	Нэмэгдэл	38,666,746.00	54,902,402.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,896,713.31	14,958,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,058,500.00	30,407,406.00
210201	Тэтгэврийн даатгал	18,879,700.00	20,861,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,044,700.00	2,354,463.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,635,800.00	1,972,784.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,900.00	472,678.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,089,400.00	4,746,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,440,850.66	43,581,132.00
210301	Гэрэл, цахилгаан	8,886,345.00	9,064,686.00
210302	Түлш, халаалт	36,529,737.66	34,416,446.00
210303	Цэвэр, бохир ус	24,768.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,062,090.00	15,366,130.00
210401	Бичиг хэрэг	2,843,750.00	3,183,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,511,360.00	9,538,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,706,980.00	1,880,680.00
210404	Ном, хэвлэл	-	279,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	485,000.00
2105	Нормативт зардал	715,185.00	499,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	715,185.00	499,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,550,010.00	2,671,946.00
210604	Урсгал засвар	1,666,010.00	2,671,946.00
2107	Томилолт, зочны зардал	8,108,000.00	1,218,000.00
210702	Дотоод албан томилолт	6,608,000.00	1,218,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,863,975.00	3,948,975.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,096,816.00	3,190,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	318,284.00	287,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	352,875.00	146,575.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,905,453.14	128,328,714.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,925,453.14	128,328,714.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,615,203.34	55,521,459.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,986,000.00	21,694,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	21,694,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,629,203.34	33,827,259.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,629,203.34	33,827,259.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>64,719,990.00</u>	<u>7,298,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>64,719,990.00</u>	<u>7,298,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>64,719,990.00</u>	<u>7,298,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	64,719,990.00	7,298,000.00
222001	Тоног төхөөрөмж	64,719,990.00	7,298,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(64,719,990.00)</u>	<u>(7,298,000.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,692,440,988.24		3,279,187,539.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,692,440,988.24	-	3,279,187,539.98
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(163,060,968.50)		(163,060,968.50)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,529,380,019.74	-	3,116,126,571.48
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,529,380,019.74	-	3,116,126,571.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	408,140.00		408,140.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,529,788,159.74	-	3,116,534,711.48
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	202,236,282.95		202,236,282.95
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,732,024,442.69	-	3,318,770,994.43

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Засаг даргын тамгын газрын дарга Б.Өнөрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 02-ноос 2021 оны 02 дугаар сарын 04-ний хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном, аудитор Д.Даариймаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр эдийн засаг нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 тоот захирамжаар Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллажээ.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “14827.5 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 287118.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон

5742.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 201207.0 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2126.7	11686.5	9559.8
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	13395.5	28326.3	14930.7
Үндсэн хөрөнгө	3202041.7	3278758.2	176716.4
Нийт хөрөнгө	3117563.9	3318770.9	201207.0
Өр төлбөр	1437.4	0	-1437.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3116126.5	3318770.9	202644.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3117563.9	3318770.9	201207.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй тайлагнажээ.

Авлага дансны үлдэгдэл 11686.5 мянган төгрөг болж 9559.8 мянган төгрөгөөр өссөн нь оны эхний байгууллагаас авах авлага 1029.6 мянган төгрөгийг барагдуулснаас, 10589.1 мянган төгрөгийн нэмэлт дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг авлагад тусгаснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 1990-1995 онуудад үүссэн, он дамжсан 1097.4 мянган төгрөгийн эзэн холбогдогч тодорхойгүй авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 1097.4 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28326.3 мянган төгрөг болж 14930.7 мянган төгрөгөөр өссөн нь 62413.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 47482.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 327758.2 мянган төгрөг болж 201207.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 7298.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 365429.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл хувь хүмүүст төлөх 1437.4 мянган төгрөгийн өр барагдаж үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3318770.9 мянган төгрөг болж 202644.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Бүрэгхангай сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 385663.1 мянган төгрөгөөр буюу 75.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 3 орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 251785.4, хандив тусламжийн орлого 25000.0, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 59064.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 19889.8 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл, тайланд онд тэтгэвэрт гарсан нэг ажилтан байснаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 448776.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 448776.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 31903.1 мянган төгрөгөөр бууруулж 416873.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 416873.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 416163.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 710.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 418871.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 552.0, дээд шатны төсвийн захирагчаас 115293.6 нийт 534717.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 500890.1 мянган төгрөгийг зарцуулж 33827.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсвөөс 1998.3 мянган төгрөгөөр илүү санхүүжигдэж буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 500890.1 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь цалингийн зардал 1344.8, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 270.4, гэрэл цахилгааны зардал 135.4, түлш халаалтын зардал 3651.6, бичиг хэргийн зардал 6.1, тээвэр шатахууны зардал 3.7, шуудан холбоо интернетийн зардал 49.3, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал 0.6, багаж техник хэрэгслийн зардал 0.8, урсгал засварын зардал 200.4, дотоод албан томилолтын зардал 3137.4, бараа үйлчилгээний бусад зардал 6160.9, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 200.0, бусад нийтлэг ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардал 5000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, нэмэлт санхүүжилтийн данснаас 10589.1 мянган төгрөг дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 12512.9, баг, хорооны үйл ажиллагааны зардал арга хэмжээ 1131.3, орон нутгийн нөөц хөрөнгө арга хэмжээ 2043.6, хур хог хаягдал, орчны бохирдол арга хэмжээ 3500.0, хөтөлбөр төслийн дотоод урсгал арга хэмжээ 1500.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөө аж ахуйн газраас огтоно усгалын ажилд 21600.0, аймгийн Статистикийн хэлтсээс хүн ам, орон сууцны тооллогын урамшуулалд 3884.2, Өвөрхангай аймгаас отроор өвөлжиж байгаа малчин өрхүүдэд төрийн үйлчилгээг хүргэхэд 4000.0, аймгийн Байгаль хамгаалах сангаас хог хаягдал цэвэрлэх зардалд 3000.0, хогийн цэг дарж булах ажилд 27500.0, морин эргүүлийн урамшууллын зардалд 1944.0, аймгийн ОНХС-гаас дотуур байрны өртгөлд 50000.0, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүнсний дэмжлэг 500.0, “Шижирт алт” ХХК-наас ковид-19 өвчний дэмжлэгт 2265.3, аймгийн ИТХ-аас Шилдэг эрх зүйн багшийн шагналд 600.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, огтоно устгалын ажлаас 6291.3, хог хаягдал цэвэрлэх зардлаас 2171.5, ковид-19 өвчний эсрэг хандив дэмжлэгээс 180.6, хүн ам, орон сууцны тооллогын урамшууллаас 1.7, морин эргүүлийн урамшууллаас 1944.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст төвлөрүүлж авлагаар тусгасан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4817.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 4690.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	4817.9	1	4817.9			
Зөвлөмж	5	4690.0	5	4690.0			
Нийт дүн	6	9507.9	6	9507.9			

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 95401.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 93374.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 830.0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1196.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй болон хандиваар ирсэн бараа материал үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд 67184.2 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залруулсан.
2. Үнэ төлбөргүй шилжүүлсэн 10000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй гарсан зардал дансанд бүртгэж залруулсан.
3. Хандиваар ирсэн 16190.4 мянган төгрөгийн бараа материал орлогодоогүй тайланд тусгаж залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2026.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2026.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтээс цагаан сараар постонд гарсан шатахууны зардалд анхан шатны баримт, замын хуудас бүрдүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зарцуулсан шатахуунд анхан шатны баримтыг бүрдүүлэх албан шаардлага өгөх

2. Тэтгэвэрт гарсан хөдөлмөрийн гэрээгээр ажилласан ажилтанд Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон нь Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга Ц.Мөнхтулга, ажилтан С.Үүрцайх нарын 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хөдөлмөрийн гэрээнд Ажилтны үндсэн цалин “717662 төгрөг байна” гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү олгосон цалинд төлбөрийн акт тогтоох

3. Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт дахь Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү олгосон урамшуулалд төлбөрийн акт тогтоох

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар цалингийн бодолтыг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Бүрэгхангай сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			БУА-2021/30/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Бүрэгхангай сумын ЗДТГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нэмэлт санхүүжилтээс цагаан сараар постонд гарсан шатахууны зардалд анхан шатны баримт, замын хуудас бүрдүүлээгүй байна.	1196.8	Зарцуулсан шатахуунд анхан шатны баримтыг бүрдүүлэх албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Өнөрбаяр, Б.Оюунчимэг
2	Тэтгэвэрт гарсан хөдөлмөрийн гэрээгээр ажилласан ажилтанд Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.	179.4	Илүү олгосон цалинд төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Б.Өнөрбаяр, Б.Оюунчимэг
3	Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон	650.6	Илүү олгосон урамшуулалд төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Б.Өнөрбаяр, Б.Оюунчимэг
ДҮН		2026.8			

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.ДААРИЙМАА

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Бүрэгхангай сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БУА-2021/30/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Бүрэгхангай сумын ЗДТГ	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нэмэлт санхүүжилтээс цагаан сараар постонд гарсан шатахууны зардалд анхан шатны баримт, замын хуудас бүрдүүлээгүй байна.	1196.8	Зарцуулсан шатахуунд анхан шатны баримтыг бүрдүүлэх албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Өнөрбаяр, Б.Оюунчимэг
2	Тэтгэвэрт гарсан хөдөлмөрийн гэрээгээр ажилласан ажилтанд Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.	179.4	Илүү олгосон цалинд төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Б.Өнөрбаяр, Б.Оюунчимэг
3	Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон	650.6	Илүү олгосон урамшуулалд төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Б.Өнөрбаяр, Б.Оюунчимэг
ДҮН		2026.8			

ХЯНАСАН

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

Д.ДААРИЙМАА